



БИНДЭГНОРОВ ХХК



# БИНДЭГНОРОВ ХХК

ЦАХИЛГААН  
ДАМЖУУЛАХ АГААРЫН  
ШУГАМ, ДЭД СТАНЦЫН  
ЗАСВАР, УГСРАЛТ

ЦАХИЛГААН ТҮГЭЭХ

ЦАХИЛГААНААР  
ЗОХИЦУУЛАЛТАЙ  
ХАНГАХ



# БИНДЭГНОРОВ ХХК

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА, УГСРАЛТ, ЗАСВАР, ЦАХИЛГААН ТҮГЭЭХ КОМПАНИ

“Биндэгноров” ХХК нь 2006 онд гадаад худалдаа болон эрчим хүчний барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар анх үүсгэн байгуулагдсан. 2006 онд “Эрчим хүчний яам”-наас эрчим хүчний барилга угсралтын чиглэлээр, 2016 онд “Эрчим хүчний зохицуулах хороо”-ноос эрчим хүчээр зохицуулалттай хангах, түгээх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлүүдийг шат дараатай авч


үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш салбартаа тасралтгүй 16 жил ажилласан туршлагатай компани юм. Энэ хугацаанд манай компани Монгол улсын хөгжил дэвшилд чухал ач холбогдол бүхий эрчим хүчний томоохон төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажилд оролцон хувь нэмрээ оруулж байгаад бид бүхэн баяртай байдаг.

### АЛСЫН ХАРАА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТЭРГҮҮЛЭГЧ КОМПАНИ БОЛНО.

### ЭРХЭМ ЗОРИЛГО:

БИД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ ОРЧИН, УХААЛАГ ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭГ БҮРДҮҮЛЖ ХЭРЭГЛЭГЧЭЭ ДЭЭДЭЛСЭН ЧАДВАРЛАГ ХАМТ ОЛОН БОЛНО.



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

- 2006 ОНД 0.4-15 КВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, ДЭД СТАНЦЫН ЗАСВАР, УГСРАЛТ, ТҮҮНИЙ ТУРШИЛТ ТОХИРУУЛГА, ДАГАЛДАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ,
- 2009 ОНД 0.4-35 КВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, ДЭД СТАНЦЫН ЗАСВАР, УГСРАЛТ, ТҮҮНИЙ ТУРШИЛТ ТОХИРУУЛГА, ДАГАЛДАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ,
- 2013 ОНД 0.4-110 КВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД СТАНЦЫН ЗАСВАР, УГСРАЛТ ТҮҮНИЙ ТУРШИЛТ ТОХИРУУЛГА, БУСАД ДАГАЛДАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
- 2016 ОНД ЦАХИЛГААН ТҮГЭЭХ,
- 2016 ОНД ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАНГАХ
- 2021 ОНД 0.4-220 КВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД СТАНЦЫН ЗАСВАР, УГСРАЛТ ТҮҮНИЙ ТУРШИЛТ ТОХИРУУЛГА, БУСАД ДАГАЛДАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ



“Биндэгноров” ХХК нь байгуулагдсан цагаасаа хойш Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн эрчим хүч шаардлагатай газруудад 0.4 кВ, 10 кВ, 35 кВ, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 0,4 кВ, 6 кВ, 10 кВ, 35 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам, 6/0.4, 10/0.4, 35/0.4 кВ-ын дэд өртөө, 6, 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж (ХХБ), 35/10 кВ, 110/35/6 кВ-ын дэд станц зэрэг том жижиг нийлсэн 100 гаруй эрчим хүчний барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн улс эх орныхоо эрчим хүчний салбарын бүтээн байгуулалтын ажилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



## ■ АЖИЛЛАХ ХҮЧИН


Тус компани нь эрчим хүчний барилга угсралтын чиглэлээр ямар ч ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх мэргэжлийн инженер техникийн ажиллагсад, машин механизм, тоног төхөөрөмжийн чадавхитай бөгөөд санхүүгийн хувьд бусдаас хараат бус бие даасан.

Компаний хэмжээнд нийт ажиллагсдын 9%-ийг Удирдах ажилтан, 39%-ийн ИТА, 12%-ийг албан хаагч, 40%-ийг ажилчин буюу монтёр жолооч нар


эзэлж байгаа бөгөөд насны хувьд 35 хүртлэх насны залуучууд 61%-ийг, хүйсийн байдлаар эмэгтэй ажиллагсад 30%-ийг эзэлж байна.

Ажилтнуудын 51% нь 6-аас дээш жил салбартаа ажилласан дадлага туршлагатай бөгөөд 67% нь Эрчим хүчний салбарын мэргэшсэн, магистр, зөвлөх инженерийн зэрэг хамгаалсан дээд боловсролын инженер техникийн ажилтнууд юм.

Ажиллагсдын боловсролын түвшин



Ажилласан жилийн судалгаа



## ■ ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА УГСРАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

- 2015 онд Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг 110/35/10 кВ-ын "Телевиз" дэд станцаас 10 кВ-ын шинэ гаргалга гаргаж, Согоот фидерийн ачаалал хөнгөлөх 3.1км 10кВ-ын ЦДАШ, 1.5 км 10 кВ-ын ЦДКШ-ын угсралтийн ажил
- 2015 онд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хөвсгөл аймгийн "Зүүн мөрөн" хорооллын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10кВ-ын дэд станцыг шинээр барих, зураг төсөл боловсруулах, угсралт, тохируулга хийх ажил
- 2016 онд "Богд Хан-Уул"-ын арын 17,1 км авто замын гэрэлтүүлгийн ажил, алсын удирдлагатай 4-н гаргалгаатай гэрэлтүүлгийн самбар, 30 кВА чадалтай трансформатор бүхий КТПН, 120 Вт чадалтай 121 шонтой 3.63 км урт гэрэлтүүлгийн шугамын барилга угсралтын ажил
- 2016 онд Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Сэнс толгойн 7 дугаар хэсгийн гэрэл цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах 6 кВ-ын 1.185км ЦДАШ, 0.4 кВ-ын 2.09 км ЦДАШ, 250 кВА

чадал бүхий дэд станц, 204 ширхэг тоолуур суурилуулах барилга угсралтын ажил

- 2017 онд Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэх, 20000 айл өрхийг 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажил БАГЦ-23, нийт 16 ячейк бүхий иж бүрэн хуваарилах байгууламж 1 ком, шинэ хуваарилах байгууламжийн тэжээл болох 10 кВ-ын 3\*240 маркийн 5.8 км, Кеч, Монель, Цайз фидерүүдийн ачааллыг хөнгөлөх 10кВ-ын 3\*150 маркийн 2.2 км кабель шугамын угсралтын ажил
- 2018 онд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор Чингэлтэй дүүргийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар халаах шугам сүлжээний техникийн боломжийг бүрдүүлэх хөрөнгө оруулалтын ажил Багц-1" ажлын хүрээнд 35/10 кВ-ын 2х10 МВА чадал бүхий Хөгжил иж бүрэн дэд станц, 35 кВ-ийн 1,3 км ЦДАШ-ын барилга угсралтын ажил



35/10 кВ-ын 2х10 МВА чадал бүхий Хөгжил дэд станц



10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж



- 2019 он Төв аймаг Баянцагаан сумын нутагт байрлах Монголчех металл ХХК-ийн "Чулуут цагаан дэлийн уурхай"-н гадна цахилгаан хангамжийн ажил болох 0.98 км нэг хэлхээт 35 кВ-ын ЦДАШ, 2\*800 кВА чадалтай 35/0.4 кВ, 1\*800 кВА чадалтай 35/10 кВ-ын дэд станц, 10 кВ болон 0.4 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн угсралт суурилуулалт



- 2020-2022 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн 4-р багцын "Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамж"-ийн Цагаан суварга дэд станцаас Зөрлөг-3, Зөрлөг-4, Зөрлөг-5 хүртэлх 101.6 км урт 110 кВ-ын габридтай, 35 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажил
- 2021-2022 онд "Дорноговь аймгийн Сайншанд сумын 10-0.4 кВ хүчдэлийн цахилгаан түгээх сүлжээний шинэчлэлтийн ажил"







## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос олгосон 19/2016 тоот цахилгаан түгээх, 20/2016 тоот цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд батлагдсан тарифын

дагуу 2016 оноос хойш 10000 гаруй хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг тасралтгүй найдвартай түгээн, цахилгааны төлбөр тооцоо хийх үйлчилгээг 24 цагийн турш тасралтгүй явуулж байна.

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- Хан-Уул дүүрэгт байрлах 18 дугаар хорооны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 110/35/10 кВ-ын Зайсан дэд станц, Хүннү А,Б гаргалгаанд холбогдож буй хэрэглэгчид;
- Хан-Уул дүүрэгт байрлах 4 дүгээр хорооны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 110/10/6 кВ-ын Дунд гол дэд станц, Ханбогд А,Б гаргалгаанд холбогдож буй хэрэглэгчид;
- Хан-Уул дүүрэгт байрлах 2 дугаар хорооны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станц, Мишээл А,Б гаргалгаанд холбогдож буй хэрэглэгчид;
- Баянгол дүүрэгт байрлах 20 дугаар хорооны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 110/10/6 кВ-ын Дунд гол дэд станц, Хархорин А,Б гаргалгаанд холбогдож буй хэрэглэгчид;
- Баянзүрх дүүрэгт байрлах 10 дугаар хорооны “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 110/10 кВ-ын Дулаан дэд станцын 10кВ-ын, Цагдаа А,Б гаргалгаанд холбогдож буй хэрэглэгчид;

## ПРОГРАМ ХАНГАМЖ, УХААЛАГ СҮЛЖЭЭ



Бид цахилгаан эрчим хүчийг түгээх, хангах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэд техник технологи, программ хангамжийг нэвтрүүлэн

хэрэглэгчдийн сэтгэл хангамжийн баталгааг бий болгох, үйлчилгээг ойртуулах шинэчлэлтийн ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна.



TAMADUM2 ухаалаг тоолуурын нэгдсэн систем	EDIMiS програм хангамж	<a href="https://tugeeh.mn">https://tugeeh.mn</a>	CALLPro үйлчилгээ	Osticket дуудлагын систем
Байцаагч APK /андроид апп/	Billcenter	DIAMOND санхүүгийн нэгдсэн програм	Банкны онлайн биллинг үйлчилгээ	СКАДА



Ухаалаг тоолуурын нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын хүрээнд түгээх сүлжээний нийт хаалттай дэд станцын 75 хувьд ухаалаг тоолуур, концентратер суурилуулаад байгаа бөгөөд ингэснээр нэгэн зэрэг

алсын зайнаас эгшин зуурын утгаар тоолуурын бодит хуурмаг чадлын хэрэглээ, гүйдэл, хүчдэлийн заалтуудыг авах боломжийг бүрдүүлж өгсөн.



Компанийн хэмжээнд шугам тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангах, ашиглалтын түвшинг дээшлүүлэх зорилгоор жил бүр урсгал засвар, их

засвар, ТЗБАХ-ын төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж байна.



## ■ ҮЙЛЧИЛГЭЭ

Кабелийн тодруулга хийх

Трансформаторын чадал хэмжих

Тоолуур шалгах


Дуудлагын төлбөрт үйлчилгээ үзүүлэх




Шугам тоноглолын засвар, үйлчилгээ хийх



Техникийн нөхцөл олгох







 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ривер стоун хотхон, 26А-101 тоот
  75050507
  976-76066742

 Bindegnorov.llc@gmail.com, contact@bindegnorov.mn
  www.bindegnorov.mn